



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/29/

Чингис хот

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн  
хэлбэрээр орлуулан хаалгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэзсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, Улсын их хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Байлдагч, түрүүчийн алба хаах насны дээд хязгаарт хүрч, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдийн нэрсийг баталсугай.

2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг тогтоон дараагийн ээлжит цэрэг татлагын өмнө барагдуулж дуусган цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийж, цэргийн бүртгэлд тусгаж ажиллахыг Цэргийн штабын дарга (хурандаа Н.Хүрэлээ)-д даалгасугай.

3. Төлбөрийн орлогыг Хэнтий аймгийн төрийн сан банкны 100180051401 тоот дансанд төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011894